

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2026 оны 01 дугаар
сарын 05 ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ гэрээг нэг талаас “Эдийн засгийн хөгжлийн төв” УТУГ (РД: 6838251) (цаашид “Захиалагч тал” гэх), түүнийг төлөөлж Захиргааны удирдлагын хэлтсийн дарга Г.Алтансүх, нөгөө талаас Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар (РД: 5340659) (цаашид “Гүйцэтгэгч тал” гэх), түүнийг төлөөлж Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Н.Оюунцэцэг, (цаашид хамтад нь “Талууд” гэх) нар Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны 149 дүгээр тогтоолын 4 дэх заалт болон холбогдох бусад хууль, эрх зүйн актыг удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

1.2. Гүйцэтгэгч тал болон Захиалагч тал хамтран энэ гэрээнд заасан ажлыг тухайн хугацаанд хийж гүйцэтгэхэд гэрээний зорилго оршино.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1. Гэрээний үйлчлэх хугацаа нь 1 /нэг/ жил буюу 2026 оны санхүүгийн тайлангийн жилд хүчинтэй байна.

2.2. Талууд гэрээний үйлчлэх хугацааг нэг талын бичгээр гаргасан хүсэлт, нөгөө талын зөвшөөрлөөр сунгаж болно.

Гурав. Гүйцэтгэгч талын үзүүлэх нийтлэг үйлчилгээ

3.1. Цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны үйлчилгээний талаар:

3.1.1. цахилгаан, дулаан, сантехник, цэвэр бохир усны байгууламжийн найдвартай ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хангах;

3.1.2. цахилгаан, сантехникийн бүх төрлийн урсгал засварын үйлчилгээг хийх;

3.1.3. дулаан, цэвэр, бохир усыг тогтоосон хугацаанд жигд дамжуулж хэвийн горимоор хангаж ажиллах;

3.1.4. сантехникийн шугам, радиатор, вентель, крант, гоожууруудын ажиллагааг тогтмол шалгаж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах;

3.1.5. дулааны узелийн өрөөнүүдийн тоноглолын хэвийн ажиллагаанд тогтмол хяналт тавьж, үзлэг, тохируулга хийх;

3.1.6. шугам сүлжээний их засвар, урсгал засварын ажлын хэмжээг тогтоож, тоолуур хэмжих хэрэгсэлд бүрэн хамруулж аль болох хэмнэлттэй ажиллах;

3.1.7. цахилгааны төв щитэд тогтмол үзлэг хийж, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах;

3.1.8. өрөө, тасалгаа, нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэг, унтраалга, залгуур зэрэг цахилгааны холбогдолтой засвар үйлчилгээг тогтмол хийж, хонгил, заалнуудын гэрлүүдийг шалгаж, шаардлагатай үйлчилгээг хийж хэвийн үйл ажиллагааг хангах;

3.1.9. гол щит болон давхрын хуваарилах самбаруудад засвар, үйлчилгээ тогтмол хийж хэвийн ажиллагааг хангах;

3.1.10. дулаан, цэвэр бохир ус, цахилгааны гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулж, үйлчилгээний төлбөрийг тухай бүр төлж байх.

3.2 Барилгын урсгал засвар, мужааны үйлчилгээ

3.2.1. эд хогшлын гэмтлийг тухай бүр сэлбэн, засварлахад туслах;

3.2.2. өрөө тасалгаа, нийтийн эзэмшлийн газрын шал, хаалга, цонх, салхивч зэргийг засварлах, шиллэх, дулаалах, хаалганы нугас, бариул, түгжээ, цоож суурилуулах, засварлах зэргийг хийж гүйцэтгэх;

3.2.3. Захиалагч талтай харилцан тохиролцсоны дагуу барилгын урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэх.

3.3. Цэвэрлэгээ үйлчилгээний талаар

3.3.1. албан өрөөний өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг стандартын дараалал баримтлан хийж гүйцэтгэн цэвэр орчин бүрдүүлэх;

3.3.2. өрөө тасалгаа, нийтийн эзэмшлийн талбайн их цэвэрлэгээг сард 2 удаа хийх;

3.3.3 хивс дрожийг зориулалтын машинаар сард нэгээс доошгүй удаа угааж, шаардлагатай тохиолдолд тухай бүр угааж цэвэрлэх;

3.3.4. өрөө тасалгаанд байрлах цэцэг болон тасалгааны ургамлын арчилгааг тогтмол хийх;

3.3.5. нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, үйлчилгээг стандартын дагуу тогтмол хийх;

3.3.6. нийт өрөө тасалгаанд шаардлагатай тохиолдолд хортон шавжийн устгал, халдваргүйжүүлэлт хийх;

3.3.7. өдрийн жижүүр-үйлчлэгчийг ажиллуулах;

3.3.8. өвлийн бэлтгэл ажлыг цаг тухайд нь хангаж, цонхыг дулаалж байх;

3.3.9. ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгалыг стандартын дагуу тогтмол гүйцэтгэж хэвийн байдлыг хангах.

Дөрөв. Ажлын хөлс

4.1. Ажлын хөлс буюу Гүйцэтгэгч тал гэрээний хугацаанд Захиалагч талын эзэмшиж байгаа объектыг дулаан, цахилгаан эрчим хүч, усаар хангаж, үүнтэй холбогдуулан гарах дулаан, сантехник, цахилгаан хангамж, цэвэр бохир усны төлбөр, тоног төхөөрөмж, запаас сэлбэг болон аж ахуйн материал, эд хогшил, барилгын урсгал засварт үзүүлэх ажил, нийтлэг үйлчилгээний зардал болон үйлчилгээний ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалтаас шалтгаалах төлбөр, бусад нийтлэг үйлчилгээнд зарцуулах зардал 73,025,800 (Далан гурван сая хорин таван мянга найман зуу) төгрөг байна.

4.2. Энэ гэрээний 4.1-д заасан төлбөрийг энэ гэрээний хавсралтад заасан хуваарийн дагуу Гүйцэтгэгч талын дараах данс /Худалдаа хөгжлийн банк -499230423/-нд шилжүүлнэ:

4.3. Энэ гэрээний 4.1-д заасан тогтмол зардал (улсаас тогтоодог нэгж үнэ) нэмэгдсэн тохиолдолд уг нэмэгдсэн үнийн дүнгийн зөрүүгээр зардлын дүнг нэмэгдүүлж тооцно.

4.4. Энэ гэрээний 4.1-д заасан ажил, нийтлэг үйлчилгээний үнэд өөрчлөлт оруулах тохиолдолд Талууд харилцан тохиролцож энэ гэрээнд өөрчлөлт оруулна.

Тав. Захиалагч талын эрх, үүрэг

5.1. Захиалагч тал дараах эрх эдэлнэ.

5.1.1. Гүйцэтгэгч талын үйл ажиллагаанд саад болохгүйгээр хийж гүйцэтгэсэн ажил, нийтлэг үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавих;

5.1.2. Гүйцэтгэгч талыг энэ гэрээнд заасан ажил, үйлчилгээг чанартай, зохих ёсоор гүйцэтгэхийг шаардах, шаардлагатай бол ажлын гүйцэтгэлийг ажлын даалгаварт зааснаар залруулахыг шаардах, шаардлагаа Гүйцэтгэгч талд бичгээр мэдэгдэх;

5.1.3. Гүйцэтгэгч талын гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол илэрвэл түүнийг арилгуулах;

5.1.4. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах;

5.1.5. Тухайн жилд гүйцэтгүүлэх ажил, нийтлэг үйлчилгээ (бүтээгдэхүүн)-ний талаар Гүйцэтгэгч талтай харилцан тохиролцож хамтран ажиллах гэрээ байгуулах;

5.2. Захиалагч тал дараах үүрэг хүлээнэ:

5.2.1. Энэ гэрээний 4.1-д заасан ажлын хөлс, төлбөрийг мөн гэрээний 8.1-т заасан хуваарийн дагуу Гүйцэтгэгч талд төлөх;

5.2.2. Энэ гэрээний 1 дүгээр хавсралтад заасан ажил, нийтлэг үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах баримт бичиг болон бусад мэдээллийг өгөх;

5.2.3. Гүйцэтгэгч талыг энэ гэрээнд заасан ажил, нийтлэг үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах ажлын нөхцөлөөр хангах;

5.2.4. Тухайн жилд худалдан авах ажил, нийтлэг үйлчилгээний нийт зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчтай тохиролцон тооцож бүрдүүлэх;

5.2.5. Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хариуцах.

Зургаа. Гүйцэтгэгч талын эрх, үүрэг

6.1. Гүйцэтгэгч тал дараах эрх эдэлнэ.

6.1.1. Захиалагч талтай урьдчилан тохиролцсон ажил, нийтлэг үйлчилгээний төлбөрийг бүрэн нэхэмжлэн авах;

6.1.2. Захиалагч талын байрны ашиглалтыг сайжруулах, хэрэглээг багасгах арга хэмжээ авснаар гаргасан хэмнэлтийг шаардлагатай бусад засвар, үйлчилгээнд зарцуулах болон хуримтлуулах;

6.1.3. Захиалагч талын шаардлагаар үүссэн ажил, нийтлэг үйлчилгээг нэмэлт гэрээ байгуулан гүйцэтгэх;

6.1.4. Барилга, байшин цахилгаан, ус, дулаан, сантехникийн урсгал засвартай холбоотой асуудлыг батлагдсан зардлын хүрээнд хийж гүйцэтгэх.

6.2. Гүйцэтгэгч тал дараах үүрэг хүлээнэ:

6.2.1. Энэ гэрээнд заасан ажил, нийтлэг үйлчилгээг Захиалагч талын ажлын даалгаврын дагуу тогтоосон хугацаанд стандарт, чанарын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх;

6.2.2. Энэ гэрээнд заасан ажил, нийтлэг үйлчилгээний гүйцэтгэлд гарсан чанар, стандартын доголдлыг түргэн шуурхай засаж, Захиалагч талын хэвийн үйл ажиллагааг хангах;

6.2.3. Ажил, нийтлэг үйлчилгээтэй холбогдолтой мэдээ мэдээллийг Захиалагч талын хүссэн тухай бүрд гаргаж өгөх;

6.2.4. Захиалагч талын өрөө тасалгаанд ажил, нийтлэг үйлчилгээ явуулахдаа тухай байгууллагын болон албан хаагчдын баримт бичиг, эд зүйлс, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, албаны болон хувийн нууцыг чандлан хадгалах.

Долоо. Нууцлал хадгалах

7.1. Гүйцэтгэгч тал энэ гэрээнд заасан үүргээ биелүүлэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүнтэй холбоотой нууц мэдээллийг гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр мэдээлэх, дамжуулах, тараахыг хатуу хориглох бөгөөд зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

Найм. Хариуцлага

8.1. Захиалагч тал ажил, нийтлэг үйлчилгээний төлбөрийг улсын төсвийн санхүүжилтийн эрх нээгдээгүйгээс бусад тохиолдолд тухайн сарын 10-ны өдрийн дотор шилжүүлэх ба хэрэв зайлшгүй шаардлагаар төлбөрийг шилжүүлэх хугацаа хэтэрсэн бол шалтгаанаа албан бичгээр тайлбарлан ажлын 3-5 өдрийн дотор гүйцэтгэгч талд хүргүүлнэ.

8.2. Хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас аль нэг талд хохирол учирсан тохиолдолд уг хохирлыг гэм буруутай тал нь бүрэн хариуцаж арилгана.

8.3. Хохирол барагдуулсан үйлдэл нь Талуудыг энэ гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

8.4. Талууд энэ гэрээг гэрээний хугацаа дуусахад хамтран дүгнэж, төлбөр тооцоог харилцан дуусгаж энэ тухай акт үйлдсэнээр дуусгавар болгоно.

Ес. Бусад

9.1. Талууд энэ гэрээг нэг талын санаачилгаар цуцлахгүй.

9.2. Аль нэг Тал нь энэ гэрээг цуцлахыг хүсвэл 14-өөс доошгүй хоногийн өмнө нөгөө талд асуудлаа албан бичгээр мэдэгдсэний үндсэн дээр зохих шийдвэрийг хамтран гаргана.

9.3. Хэрэв энэ гэрээнд заасан болон түүнтэй холбогдох асуудлаар маргаан гарвал Талууд хэлэлцээний замаар шийдвэрлэх арга хэмжээг авна. Маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэж чадахгүйд хүрвэл хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлнэ.

9.4. Энэ гэрээ түүнд Талууд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.5. Энэ гэрээний 2.2-т зааснаас бусад гэрээний хугацаа, нөхцөлийн талаар өөрчлөлт оруулах бол Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

9.6. Энэ гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр үйлдэж, Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

9.7. Энэ гэрээг хоёр хувь үйлдэж тал тус бүр нэг нэг хувийг хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Г.АЛТАНСҮХ
Утас:


АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

 Б.ШҮРЭНЦЭЦЭГ
Утас: 88118627


Хаяг: Чингэлтэй дүүрэг 4-р хороо,
Засгийн газрын II байр, Б корпус

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Н.ОЮУНЦЭЦЭГ
Утас: 88118604

САНХҮҮ, БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
НЯГТЛАН БОДОГЧ

 Г.АНХБАЯР
Утас: 11-263128

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ГЭРЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Д.ӨНӨРСАЙХАН


Хаяг: Чингэлтэй дүүрэг 4-р хороо,
Засгийн газрын XII байр

ЗГБНУГ-аарын Захиралын 2026 оны
дугаар сарын ... өдрийн..... дугаар
 гэрээний хавсралт

**Эдийн засгийн хөгжлийн төсө, Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын хооронд
 20... оны ...-р сарын ...-ны өдөр байгуулсан тоот гэрээний хавсралтын задаргаа**

№	Үйлчилгээний нэр	нийт төсөв	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
Байрны нийт талбай м2			386.9											
Өрөөний талбай м2			267.27											
Нийтийн эзэмшил			121.67											
1	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	66,387.09	5,531.79	5,532.30	5,532.30	5,532.30	5,532.30	5,532.30	5,532.30	5,532.30	5,532.30	5,532.30	5,532.30	5,532.30
	НӨАТ	6,538.71	553.18	553.23	553.23	553.23	553.23	553.23	553.23	553.23	553.23	553.23	553.23	553.23
	Нийт зардлын дүн	73,025.80	6,084.97	6,085.53	6,085.53	6,085.53	6,085.53	6,085.53	6,085.53	6,085.53	6,085.53	6,085.53	6,085.53	6,085.53
	1м2 талбайд зарцуулах зардал	187.76	15.65	15.65	15.65	15.65	15.65	15.65	15.65	15.65	15.65	15.65	15.65	15.65

Тайлбар: 2026 онд ажилчдын цалин хөлс, гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр боиخر усны үнэд өөрчлөлт орвоол тухай бүр нь тодотгол хийхээр гэрээнд заасан болно.

Захиргааны удирдлагын хэлтсийн дарга



Ахлах нягтлан бодогч

Утас: 70116838

Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга



Нягтлан бодогч

Утас: 263128

Г.Анхбаяр